

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан 29/03 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Богд сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.Аудитын зорилго:

Сумдын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх.

2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдсөн тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмжүүд
1.Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө хийхдээ төсөв санхүүтэйгээ уялдуулан хийдэггүй.	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийж батлуулахдаа батлагдсан төсөвтэйгөө уялдуулан арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээг тусган сумын Засаг даргаар батлуулж хэвших 2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрд зарцуулсан хөрөнгийг тусгаж байх 3.Төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байгаа болон хэрэгжүүлэхэд хөрөнгө байхгүй арга хэмжээг дараа онд хэрэгжүүлэхээр хойшлуулах зэргээр

	<p>зохицуулалтыг хийж, тайландаа тусган ажиллах</p>
<p>2.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.</p>	<ol style="list-style-type: none"> 1.Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох 2.Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх 3.Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах 4.Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх 5.Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах 6.Эрсдэлийн удирдлагыг гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах 7.Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах 8.Нэг албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах 9.Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
<p>3. Дотоод хяналтын нэгж хяналтыг муу хэрэгжүүлдэг. Жил бүр нэг хэв маягаар ор нэр төдий хяналтыг хийдэг.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Дотоод хяналтын нэгжийн журмаа өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах 2. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын нэгжийн ажлыг үнэлэн, биелэлтийг тооцож үр дүнд суурилсан урамшууллыг хууль тогтоомжид нийцүүлэн олгох асуудлыг тусгаж өгөх 3. Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх

	<p>байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх</p> <p>4. Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх</p> <p>5. Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх</p>
<p>4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй</p>	<p>1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулахын тулд мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө, сургалт авах</p> <p>2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах</p>
<p>5. Томилолтын хуудас засвартай байхад томилолтын зардал олгосон, анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад зардал шилжүүлсэн.</p>	<p>1. Албан хаагчдын томилолтын хуудас засвартай тохиолдолд томилолтын зардал олгохгүй байх, зардлын гүйлгээнд тавих хяналтыг сайжруулах;</p> <p>2. Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил, гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг мөрдөж ажиллах;</p>